


МОНГОЛЫН БӨӨГИЙН “ТЭНГЭРИЙН СҮЛДЭР” ХОЛБОО

2010 оны 8дугаар сар 4 өдөр

Улаанбаатар хот

ЮНЕСКО –гийн Монголын
Үндэсний Коммист



Манай холбоо нь 2003 онд байгууллагдаж долоон жил үйл ажиллагаагаа тогтмол явуулж байгаа бөгөөд Монголын бөө, бөө мөргөлийн зан үйлийг олон түмэнд таниулах өв уламжлалыг зөв сэргээн хөгжүүлэхэд чиглүүлдэг.

Зургаан зуугаад гишүүнтэй. Ашигийн бус ТББ болно.

Монгол бөө мөргөл гэдэг бол монголын соёлын чухам үнэт зүйлийн нэг мөн тул энэ ёс уламжлалаа монгол улсын төр засаг, ард түмэн дэмжин хөгжүүлж цаашид өв соёлоо уламжлуулах ажил үйлсийг өрнүүлж байх шаардлагатай.

Энэ хэрэгцээ шаардлагын дагуу монгол бөө мөргөлийн ЮНЕСКО-гийн Соёлын Өвийн Төлөөллийн жагсаалтанд бүртгүүлэх хүсэлтэй байгаагаа илэрхийлж байгааг хүлээж авна уу.



Гүйцэтгэх захирал:

 Н.Энхбаатар

**“MAJESTIC HEAVENS”
ASSOCIATION OF MONGOL SHAMANS**

04 August 2010

Ulaanbaatar

To Mongolian National Commission for UNESCO

The Association established in 2003, and since then routinely functioning. Our main purpose is to correctly revive and lead the development of Mongolian shamanism to an accurate path. Moreover to promote and enable information and knowledge of Mongolian shamanism for the public. We have about six hundred members and a non-governmental and non-profit organization.

Shamanism is an invaluable element of Mongolian culture. In that sense Mongolian State and the public promote shamanism and act on to transmit it to our younger generation. Concerning such a necessity officially request to register Mongolian shamanism in the UNESCO representative list of cultural heritage.


Sincerely,

N.Enkhbaatar,

Executive Director



Азийн бөөгийн “ТИВ ДЭЛХИЙ” холбооны
Монгол бөөгийн “ГОЛОМТ” төв



201 0 оны 08 сарын 06 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот
Регистр: №

ЮНЕСКО-ИЙН МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ
КОМИССТ

Хүсэлт гаргах тухай

Манай холбоо нь 1996 оны 5-р сарын 1-нд байгуулагдан тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Тус холбоо нь 10000 гишүүнтэй бөгөөд гадаад харилцаагаа өргөжүүлэн гадаадын олон судлаач, байгууллагуудтай тухайлбал Солонгосын бөөгийн холбоотой хамтран ажиллаж байна.

Монголын бөө, бөө мөргөлийн зан үйлийг олон түмэнд таниулах өв уламжлалыг сэргээн хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг юм.

Монгол бөө мөргөл гэдэг нь Монгол соёлын үнэт зүйлсийн нэг тул Монгол бөө мөргөлийг ЮНЕСКО-ийн Соёлын Өвийн Төлөөллийн жагсаалтанд бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авч бүртгэж өгнө үү.



ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ

ҮӨВИЙН ТЭРГҮҮН

М.Сүхбат

Ш.СҮХБАТ

Tiv Delkhii Association of Asian Shamanism Golomt Center of Mongolian Shamanism

06 August 2010

No15

Ulaanbaatar
Registration...

To Mongolian National Commission for UNESCO

Official Consent

The Association established on the 1st of May 1996, and since then routinely functioning. Our main purpose is to promote and enable Mongolian shamanism and shamanic ceremonies for the public. We have 10 000 members and extending our collaboration to foreign shamans, researchers and organizations, specifically with Korean shamanic association.

Shamanism is an invaluable element of Mongolian culture therefore we officially express our consent and request to register Mongolian shamanism in the UNESCO cultural heritage representative list.

Sincerely,

Sh. Sukhbat,

President of the Association and
Director of the Center

Bayangol District, 15th Sub-district
Damdindbazar Street, Building of Bayanshireet CoLtd

Tel: 99871460



BTV ТЕЛЕВИЗ

201 0 оны 07 сар 09 өдөр

№ 552

Улаанбаатар хот

ЮНЕСКО-гийн МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ-д

“BTV” телевиз нь 2009 оны 6-р сарын 20-ны өдрөөс эхлэн Улаанбаатар хотод албан ёсоор эфирээ цацаж эхэлсэн.

Манай телевиз олон нийтийг бизнес, ажил амьдралдаа ухаалаг шийдвэр гаргаж, амжилтад хүрэхэд нь туслахуйц эдийн засаг санхүүгийн хамгийн бодит, найдвартай мэдээ мэдээллээр хангахыг гол зорилгоо болгож байна. Нэвтрүүлгийн бодлого нь зөвхөн нэг салбараар хязгаарлагдахгүй уул уурхай, хөдөө аж ахуй, аж үйлдвэрлэл, дэд бүтэц, түүх соёл, үндэсний өв уламжлал зэрэг салбар бүрийн мэдээ мэдээллийг үзэгчдэд илүү гүн гүнзгий мэргэжлийн түвшинд сурвалжлан хүргэхэд оршино.

Бид түүх соёл, үндэсний өв уламжлалын сэдвийн хүрээнд Өвөг дээдсийнхээ тэнгэр дээд ухаан уламжлал, ёс зан заншил, соёлын нэгээхэн хэсэг болох Бөө мөргөлийг мэдээллийн шинж чанар агуулга талаас нь цуврал нэвтрүүлэг болгон хүргэдэг юм.

ЮНЕСКО-гийн хүн төрлөхтөний соёлын өвийн “төлөөлийн жагсаалтанд” Монгол бөө мөргөлийг бүртгүүлэн оруулах ажил хэрэгжиж эхлээд байгаа юм. Энэ үйл хэргийг манай байгууллага монголын олон бөө нарыг төлөөлөн машид дэмжиж, талархаж байгаагаа албан ёсоор илэрхийлэхийн ялдамд энэ ажлын хүрээнд зохиогдох аливаа ажиллагааг дэмжин оролцох хүсэлтэй байгаагаа мөн энэ дашрамд сонордуулмаар байна.

Хүндэтгэсэн



ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Г.БАЯНЖАРГАЛ

BTV TELEVISION

09 July 2010

No552

Ulaanbaatar

To Mongolian National Commission for UNESCO

“BTV” established and officially started broadcasting in Ulaanbaatar on the 20th of June 2009. The objectives of BTV is to supply the public with accurate business knowledge and information to support them gaining achievements in their work and life. Our policy is not to be limited to certain subjects and fields rather to cover all possible fields such as mining, agriculture, industry, infrastructure, history, traditional cultural heritage and customs. We aim to conduct in depth interviews in the professional level on various fields to enable the public gain fruitful information.

In the range of the field of national history and cultural heritage we produce a series of TV program to supply information on Mongolian shamanism which is an important part of Mongolian ancestral knowledge, belief and customs.

An implementation of the project to register Mongolian shamanism in UNESCO cultural heritage representative list is commenced. We, representing hundreds of Mongolian shamans, are officially declaring our consent to register the element. Using the opportunity we would like to inform that BTV will be delighted to participate and promote any activities organized in the scope of the registration and further tasks.

With respect,

G.Bayanjargal,

General Director